



МӨНГӨНИЙ СТАТИСТИК МЭДЭЭЛЭЛД ОРУУЛСАН ӨӨРЧЛӨЛТ

Зарим банкуудын бүртгэлийг залруулснаас Банкуудын нэгдсэн тайланд: 2011 оны 4 дүгээр сард пассив талд Мөнгөний захын хэрэгслүүд 5 тэрбум төгрөгөөр буурч, банк хоорондын репо 2.5 тэрбум, Монголбанкнаас авсан зээл 2.5 тэрбум төгрөгөөр тус тус нэмэгдэв. 2011 оны 5 дугаар сард актив талд Засгийн газраас авах авлага 0.3 тэрбум төгрөгөөр өсч, бусад авлага энэ хэмжээгээр буурав. 2011 оны 6 дугаар сард актив талд банкны нөөц 1.2 тэрбум, Засгийн газраас авах авлага 1.3 тэрбум төгрөгөөр тус тус нэмэгдэж, бусад актив 2.5 тэрбум төгрөгөөр буурав. Хувийн хэвшлийн валютын зээл 1.5 тэрбум төгрөгөөр нэмэгдэж, иргэдийн зээл энэ хэмжээгээр багасав. Харин пассив талд Монголбанкнаас авсан зээл 88.5 тэрбум төгрөгөөр нэмэгдэж, банк хоорондын репо зээл энэ хэмжээгээр буурав.

Бюллетеньд: Мөнгөний тойм хэсэгт Засгийн газраас авах цэвэр авлага, хувийн хэвшил, иргэдээс авах авлага, бусад цэвэр зүйл, банкны нөөц дээрхтэй адил өөрчлөгдөв.

МОНГОЛБАНК